



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 472

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2, 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтууд, Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны А/107 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 99,799,200.00 (ерэн есөн сая долоон зуун ерэн есөн мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 1 дүгээр хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Увс аймгийн Малчин сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 150,000,000.00 (нэг зуун тавин сая) төгрөгийн балансын үнэ 45,000,000.00 (дөчин таван сая) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 дугаар хавсралтад заасан автомашиныг төрийн өмчид хүлээн авч "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Мөнхзул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашинуудыг бүртгэх, данснаас хасах, хүлээлцэх ажлыг зохион байгуулах;

3.2. Нэгдүгээр хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд (Увс аймгийн Малчин сумын Засаг даргын Тамгын газар) эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

3.3. Орон нутгийн өмчөөс хүлээн авч буй 2 дугаар хавсралтад заасан хөрөнгийн шинэчилсэн үнэлгээг хийлгэж, бүртгэлд тусгах;

3.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.5. Автомашины улсын дугаар, татвар төлөгчийн бүртгэлийг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

137001748

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д. Нарангэрэл Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны... дугаар сарын...-ны өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АКТАЛЖ,
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

№	Автомашины марк улсын дугаар	Ашиглал- тад орсон огноо	Арлын дугаар	Балансын нийт үнэ	Хуримтлагд- сан элэгдэл	Үлдэгдэл өртөг
				(төгрөг)		
1	Ландкрузер-200 00-56 УБЗ	2011.09.08	JTMNU09JX040 41280	99,799,200.0	99,799,200.0	0.0
ДҮН				99,799,200.0	99,799,200.0	0.0
				/ерэн есөн сая долоон зуун ерэн есөн мянга хоёр зуун/	/ерэн есөн сая долоон зуун ерэн есөн мянга хоёр зуун/	

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
128 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

“ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

№	Автомашины марк улсын дугаар	Ашиглал- тад орсон огноо	Арлын дугаар	Балансын нийт үнэ	Хуримтлагд- сан элэгдэл	Үлдэгдэл өртөг
				(төгрөг)		
2	Ландкрузер-200 19-09 УВС	2012.11.20	JTMHX05J4040 22091	150,000,000.0	45,000,000.0	105,000,000.0
ДҮН				150,000,000.0	45,000,000.0	105,000,000.0
				/нэг зуун тавин сая/	/дөчин таван сая/	/нэг зуун таван сая/